



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 474

Улаанбаатар хот

### Зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.8, 5.5, 6.2.2, 6.2.4, 6.2.5, 6.4.5, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2018 оны 02-07-383/712 дугаар актаар тогтоогдсон, нийт 95,113,469.62 (ерэн таван сая нэг зуун арван гурван мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 36,233,702.72 (гучин зургаан сая хоёр зуун гучин гурван мянга долоон зуун хоёр төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны эзэмшлийн Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд байрлах контор гараажийн зориулалттай 3271 м.кв талбай бүхий газрын эзэмших эрхийг тус байгууллагад хэвээр үлдээж зориулалтыг “үйлчилгээтэй орон сууц”-ны болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Үл хөдлөх хөрөнгийн газар (чөлөөлөгдөх талбай)-ын зориулалт өөрчлөгдөж байгаатай холбогдуулан санхүүгийн тайланд бүртгэлтэй эрхийн үнэлгээнд өөрчлөлт оруулах саналыг ирүүлэн шийдвэрлүүлэх;

3.3.Үйлчилгээтэй орон сууцны барилгын үйлчилгээний хэсгээс Цагдаагийн ерөнхий газрын эзэмшил буюу төрийн өмчид авч ажлын байрыг бий болгох нөхцөлөөр барилга барих зөвшөөрлийг авах;

132001359

3.4.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.5.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 6 дугаар сарын 24 ны өдрийн  
174 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ  
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСАНД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн<br>нэр, байршил                                            | Ашиглалтад<br>орсон, бүртгэсэн<br>он (дахин<br>үнэлгээгээр) | Хэм<br>жих<br>нэгж | Тоо<br>хэмжээ | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг) | Балансын нийт<br>үнэ, бүртгэлийн<br>үнэ (төгрөг) | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг<br>(төгрөг) |
|-----|-----------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|--------------------|---------------|----------------------------|--------------------------------------------------|-----------------------------------|----------------------------|
| 1   | Гараашийн барилга<br>(Улаанбаатар хот,<br>Сүхбаатар дүүрэг,<br>11-р хороо)  | 1982/2018                                                   | м2                 | 626.45        | 45,920,487.55              | 45,920,487.55                                    | 17,493,519.04                     | 28,426,968.51              |
| 2   | Гараашийн барилга1<br>(Улаанбаатар хот,<br>Сүхбаатар дүүрэг,<br>11-р хороо) | 1982/2018                                                   | м2                 | 673.20        | 49,192,982.07              | 49,192,982.07                                    | 18,740,183.68                     | 30,452,798.39              |
|     | Нийт дүн                                                                    |                                                             |                    |               |                            | 95,113,469.62                                    | 36,233,702.72                     | 58,879,766.90              |